

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХЭЭ ЭДЛЭХЭД ТУЛГАРДАГ СААД БЭРХШЭЭЛ, АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

Зөвлөх М.Батбаатар

МУИС, Социологи нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, Дэд профессор

Судлаач Х.Батчимэг

Социологи, нийгмийн ажлын тэнхимийн магистрант

Orcid: 0009-0000-7696-8104

Abstract: *The participation of persons with disabilities (PWD) in the political process and in decision-making is the cornerstone for the realization of the rights of persons with disabilities. Therefore, based on research, this article examines the current situation of the political participation of PWDs, or the implementation of the right to vote and be elected. In carrying out the research work, data was collected from 71 people with disabilities through individual and focus group interviews and case studies using quantitative and qualitative research methods, and the results were analyzed by document analysis and comparison methods.*

According to the results found in this research, it can be concluded that poor infrastructure and access to information, legal regulation, and implementation limit the political participation of PWDs are insufficient; the policies and rules of political parties do not promote how to ensure the participation of PWDs; and it has been identified that there are some issues, such as non-fulfillment of obligations under international documents and conventions, that have acceded to Mongolia; and some possibilities and options for solving them are presented in the article.

Key word: *Persons with Disabilities (PWDs), law, election, political participation, implementation*

УДИРТГАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд "хөгжлийн бэрхшээлтэй хүн" гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ хэмээн тодорхойлжээ. 2022 оны байдлаар манай улсад албан ёсоор 115,115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн байна (www.1212.mn, 2023).

ХБИ-ийн хувьд улс төр, нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн, саадгүй, бие даан оролцох эрх нь дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжгүй байдал, нийгмийн хандлага ойлголт сул, хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт хангалтгүй, сонгуулийн тогтолцоо зэргээс шалтгаалан хязгаарлагддаг байдал түгээмэл тохиолддог. Мөн сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуульд оролцох эрхийг нь эрх зүйн чадамжгүй хэмээн хуулиар хязгаарласан заалт холбогдох сонгуулийн тухай хуулиудад (МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, 2020), (УИХ-ын сонгуулийн тухай, 2019), (Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай, 2020) байгаа нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчсөн хэрэг бөгөөд Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байгааг Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ)-ын сонгуулийн ажиглалтын тайлангууд болон хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хийсэн бусад судалгаа, бичвэрт олонтаа дурджээ. Монгол Улсын хэмжээнд оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд нийт ХБИ-ийн 19,2 хувийг эзэлдэг бөгөөд 22,000 орчим иргэд байдаг (ХБХХЕГ, 2023).

Энд дурдсан болон бусад мэдээлэлд үндэслэн ХБИ-ийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тоон ба чанарын судалгааны үр дүнд тулгуурлан гүнзгийрүүлж, төлөөллийн тэгш оролцоо хангагдахгүй байгаа учир шалтгааныг олон талаас нь харьцуулан авч үзэх шаардлагатай.

ЗОРИЛГО

ХБИ-ийн улс төрийн эрхээ эдлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлыг тодруулж, дараах зорилтуудын хүрээнд төлөөллийн тэгш оролцоог хангахад анхаарах зөвлөмжийг дэвшүүлнэ.

Зорилт

- ХБИ-ийн улс төрийн оролцоо, сонгох сонгогдох эрхийн талаар хууль эрх зүйн зохицуулалтыг судлах,
- Улс төрийн эрхээ эдлэх бодит нөхцөл байдалд тулгардаг асуудлыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр тодорхойлох,
- Тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх зарим боломж, арга замыг эрэлхийлж, зөвлөмжийг боловсруулах.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Судалгаанд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашигласан. Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага, кэйс судалгааны арга, баримт бичгийн шинжилгээний арга, харьцуулалтын арга зэргийг ашиглан шинжилгээ хийж үр дүнг боловсруулав.

Судалгааны түүврийг сонгохдоо ХБИ-ийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт бодит байдалд ямар байгааг судлахын тулд аль болох сонгуулиа тогтмол өгдөг, өгөхийг хичээдэг ХБИ ба сонгуулийн аль нэг шатанд нэр дэвшиж өрсөлдөж байсан ХБИ гэдэг шалгуураар сонгосон. Судалгаанд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотууд болон Хэнтий, Баянхонгор, Сэлэнгэ, Дорнод, Өмнөговь, Увс, Завхан, Говь-Алтай аймгийн нийт 71 ХБИ хамрагдав. Эдгээр иргэдийн 62 нь сонгох эрхийн хэрэгжилтийн судалгаанд, 9 нь сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит байдлын судалгаанд оролцов.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Монгол Улсад ХБИ-ийн улс төрийн эрхийн хэрэгжилтийн байдлыг тухайлан судалсан судалгаа хомс байдаг. Харин хүний эрх, эрх чөлөөний талаар хийсэн судалгаа болон сонгуулийн ажиглалтын тайлангуудад зарим талаар товч дурдагдсан байна. Тухайлбал, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ)-ын сонгууль ажиглах тусгай хорооны 2013, 2016, 2017, 2020, 2021 оны сонгуулийн ажиглалтын тайланд ХБИ-ийн сонгуульд оролцох эрх зүйн орчин хязгаарлагдмал, өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авахгүй байгаа талаар тухайн сонгууль бүрийн ажиглалтын тайланд дурдсан (АИХЭГ, 2013-2021). Мөн 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн үеэр АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн тусламжтайгаар Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн хэрэгжүүлсэн “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Монголын Багш Эцэг Эхийн Холбооноос ХБИ-ийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлүүдтэй хамтран ХБИ-ийн сонгох эрхийн хэрэгжилтэд ажиглалт хийсэн. Тайланд ажиглалтын үр дүнгээс гадна дараа дараагийн сонгуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хангахад хүртээмжийг бүрдүүлэх зорилгоор холбогдох зөвлөмжүүдийг тусгажээ (ХБИ-ийн сонгох эрхийн хэрэгжилт, 2021).

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол улс 1992 оноос 2021 оны хооронд ардчилсан, чөлөөт, бүх нийтийн сонгуулийг нийт 24 удаа зохион байгуулсанаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 8, УИХ-ын болон орон нутгийн ээлжит сонгууль тус бүр 8, 8 удаа байна. Мөн 1997 – 2021 оны хооронд УИХ-ын 8 удаагийн нөхөн сонгуулийг 12 тойрогт зохион байгуулжээ (Сүхбаатар.Ш, Дэлгэрнарэн.П, 2022).

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн ерөнхий нэршил дор олон янзын бэрхшээлтэй хүмүүс байх бөгөөд бэрхшээл тус бүрд тулгардаг асуудлууд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс шалтгаалан өөр өөр байна (Хөгжлийн бэрхшээлийн төрөл, 2023).

Судалгааны үр дүнг хууль эрх зүйн орчин, сонгох болон сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит нөхцөл гэсэн үндсэн 3 дэд хэсэгт ангилан боловсруулав.

1. Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хууль 1 дүгээр зүйлийн 2-т тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, 21 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3-т нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, 16 дугаар зүйлийн 9-д иргэн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй, 10 дугаар зүйлийн 3-т Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заажээ (Үндсэн хууль, 1992). Монгол Улс нь Хүний Эрхийн Түгэмэл Тунхаглал (ХЭТТ), Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт (ИБУТЭТОУП), Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Тухай Конвенц (ХБХ эрхийн тухай конвенц, 2008), Ази, Номхон Далайн Бүс Нутаг Дахь Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн “Эрхийг нь бодитой болгох” Инчоны Стратеги (Инчоны Стратеги, 2012) зэрэг олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг Монгол Улс 2016 онд соёрхон баталсан бөгөөд энэ хуулийн 30 дугаар зүйлд улс төр, нийгмийн үйл ажиллагаанд оролцох талаар тусгайлан заасан (ХБХ эрхийн тухай, 2016). Сонгуулийн тухай хуулиудад сонгох, сонгогдох эрх болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг санал өгөх боломжоор хангасан байхыг хуульчилсан. Эрх зүйн чадамжгүй гэх сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхийг нь хуулиар хязгаарласан заалт байгаа нь хүнийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр нь ялгаварлан гадуурхаж, эрхийг нь зөрчсөн хэрэг бөгөөд Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байгааг Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ)-ын сонгуулийн ажиглалтын тайлангууд болон хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хийсэн бусад судалгаа, бичвэрт олонтаа дурджээ (АИХЭГ, 2013-2021).

2023 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр сонгуулийн тогтолцоотой холбоотой дэвшил гарсан хэдий ч төлөөллийг хангах тал дээр жендэрийн зохицуулалтаас өөр зохицуулалт ороогүй байна. Улсын Их Хурал(УИХ)-ын сонгуулийн тухай хуулийн 46.27-д сонгуулийн сурталчилгаа нь дохионы хэлмэртэй байж болно гэж нэмж оруулсан нь сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах зохицуулалт болжээ (УИХ-ын сонгуулийн тухай, 2023), Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.5.Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана, 27.7-д хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоогоор төрийн санхүүжилтийг нэг удаа олгоно гэсэн зохицуулалтуудыг оруулжээ (Улс төрийн намын тухай, 2023). Монгол Ардын Нам (Намын үндсэн дүрэм, 2022), Ардчилсан Нам (Ардчилсан Намын дүрэм, 2024), ХҮН намын дүрэмд (ХҮН Намын дүрэм, 2022) шинжилгээ хийхэд ХБИ-ийн төлөөллийг хангах тал дээр ямар нэгэн зохицуулалт хийгээгүй байна.

2. Сонгох эрхийн хэрэгжилтийн бодит нөхцөл

Сонгох эрхийн хэрэгжилтийн бодит байдлын судалгаанд 62 ХБИ оролцов. Судалгаанд оролцогчид нь 20 – 63 насны, 44 эмэгтэй, 18 эрэгтэй. Үүнд: харааны бэрхшээлтэй 14, сонсголын бэрхшээлтэй 12, хэл ярианы бэрхшээлтэй 1, хөдөлгөөний бэрхшээлтэй 30, оюун, сэтгэцийн

бэрхшээлтэй 3 болон бусад бэрхшээлтэй 2 иргэн байна. Судалгаанд оролцогчдын 55 нь сонгуулиа тогтмол өгдөг, 5 нь заримдаа, 2 нь огт өгдөггүй гэж хариулжээ.

Харааны бэрхшээлтэй оролцогчдын 50% нь саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, 21% нь санал өгөх байр хүртээмжгүй, 14% нь тохиромжтой хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй, 7% нь хүмүүсийн харилцаа хандлага тааруу гэж хариулжээ.

Шигтгээ 1.

Эмэгтэй, харааны бэрхшээлтэй иргэн: Хамгийн сүүлийн сонгууль буюу 2021 оны сонгуулийг өгөөгүй. Учир нь өмнө өгсөн сонгууль хүртээмж маш хангалтгүй, нууцлал гэдэг зүйл огт байхгүй байсан учраас дахиж өгөх хүсэл төрөөгүй. Брайль хавтас нь зөвхөн брайль үсэг мэддэг хүмүүстээ л зориулагдсан байдаг. Сонгуулиа цахимаар өгдөг байвал их амар санагддаг. Дуут уншигчийг ашиглаад өгөх боломжтой.

Сул сонголтой 2 оролцогч, хэл ярианы бэрхшээлтэй 1 оролцогч сонгох эрхээ эдлэхэд ямар нэгэн асуудалтай тулгардаггүй гэсэн бол бүрэн сонголгүй оролцогчдын 90% нь тохиромжтой хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй, 40% нь ойлгомжтой зааварчилгаа байдаггүй, 30% нь саналаа бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, ойр дотны хүмүүсийн нөлөөнд автдаг гэж хариулжээ.

Шигтгээ 2.

Эмэгтэй, сонголын бэрхшээлтэй иргэн: Сонгуулийн үеэр нэр дэвшигчид, намууд мөрийн хөтөлбөрөө хэвлэмэл байдлаар тараадаг. Сайн уншиж, ойлгож чаддаггүй учраас хэнийг сонгохоо мэддэггүй. Дохионы хэлээр мэдээлэл авах боломжтой бол өөрөө сонголтоо хиймээр л байдаг. Даанч ч тийм боломж байхгүй болохоор гэр бүлийн хүмүүсийн хэлсэн хүнийг сонгохоос өөр аргагүй байдалд ордог.

Хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 57% нь санал өгөх байр хүртээмжгүй, 20% нь саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, 13% нь харилцаа, хандлага тааруу гэсэн бол явуулын хайрцагаар санал өгч байсан бүх ХБИ саналын нууцлал алдагдаж байсан гэж хариулав. Харин хөнгөн хэлбэрийн хөдөлгөөний бэрхшээлтэй болон бусад бэрхшээлтэй иргэдэд сонгох эрхээ эдлэхэд ямар нэгэн асуудал тулгардаггүй байна.

Шигтгээ 3.

Эрэгтэй, тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэн: Саналаа тогтмол өгдөг. Манай санал авах байр цэцэрлэгийн 2 давхарт байрладаг. Тэргэнцэртэй учраас санал өгөх тоолондоо 2 давхар луу хүмүүсээр татуулж, өргүүлж гарах нь хэцүү санагддаг. Өөрийн ажилладаг төрийн бус байгууллагаар дамжуулан санал авах байрыг хүртээмжтэй газар зохион байгуулах талаар саналаа хүргүүлж байсан ч үр дүн гараагүй.

Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдээс сонгох эрхээ эдэлдэг иргэд цөөн тоотой байсан бөгөөд судалгаанд оролцсон сэтгэцийн бэрхшээлтэй иргэнд ямар нэгэн асуудал тулгардаггүй, оюуны бэрхшээлтэй 2 хүний 1 нь тогтмол саналаа өгдөг, 1 нь сонгуульд огт оролцож байгаагүй гэв.

3. Сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит нөхцөл

Сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит байдлыг судлахаар УИХ-ын болон орон нутгийн сонгуульд **ХБИ-ийн төлөөлөл** болж нэр дэвшин өрсөлдөж байсан 9 хүнээс судалгаа авсан болно. 40-64 насны 2 эмэгтэй, 7 эрэгтэй. Бэрхшээлийн хэлбэр нь хөдөлгөөний бэрхшээлтэй 8, сонсголын бэрхшээлтэй 1. Ардчилсан Намаас 2, Иргэний Хөдөлгөөний Намаас 1, Шинэ Намаас нэр дэвшсэн 2, Иргэний Зориг Ногоон Намаас 1, бие дааж нэр дэвшсэн 3 ХБИ байна. 2000 – 2020 оны хооронд болсон УИХ-ын сонгуульд 6 ХБИ, орон нутгийн сонгуульд 3 ХБИ нэр дэвшиж өрсөлдсөн бөгөөд орон нутгийн сонгуульд 2 нь ялалт байгуулсан байна. ХБИ сонгуульд нэр дэвшихэд хамгийн их тулгардаг нь санхүү, дэд бүтэц, хандлага ойлголтын асуудлууд байна. Сонгуулийн хэсгийн хороодын зарим

албан хаагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага муу байгаагаас шалтгаалж хүний эрхийн зөрчлийн асуудал үүсэх тохиолдол гардаг байна.

Шигтгээ 4.

Эрэгтэй, сонсголын бэрхшээлтэй нэр дэвшигч: Орон нутгийн сонгуульд бие дааж нэр дэвшихээр шаардлагын дагуу гарын үсэг цуглуулаад очсон. Гэтэл, чи хөгжлийн бэрхшээлтэй учраас чадахгүй гээд бүртгэж авахаас татгалзсан. Тухайн өдрөө бичиг баримтаас бүрдүүлээд Захиргааны шүүхэд гомдол гаргасан. Шүүх бичиг баримтуудыг үндэслээд тухайн тойргийн сонгуулийн хороог хууль бус шийдвэр гаргасан гэж үзсэн. Ингээд Монгол Улсын нэрийн өмнөөс гээд шүүхийн шийдвэрээ гаргуулж нэр дэвших эрхээ авсан. Шүүхэд хандах, шийдвэр гаргуулах гэж явсаар байтал өөрийгөө сонгогчдод таниулах хугацаа маш бага үлдсэн. Ердөө 14 хоногийн хугацаанд сурталчилгааныхаа ажлыг хийсэн. Сонгогдож чадаагүй.

Сонгуульд намаас нэр дэвшихэд маш их өрсөлдөөн байдаг тул санхүүгийн боломжгүй, хүрээлэл багатай, танигдаагүй ХБИ-ийн хувьд нэр дэвших нь бараг боломжгүй зүйл. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх, улс төрийн албан тушаал хаших, нэр дэвшихэд зохицуулалт хийх, намууд бодлогоор дэмжвэл төлөөллийг хангах боломж бүрдэх тухай судалгаанд оролцогчид санал дэвшүүлсэн юм.

2020 оны ээлжит сонгуулиар жишээ аваад үзэхэд УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 2 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч, орон нутгийн сонгуульд 17,357 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 1 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч байжээ.

ДҮГНЭЛТ

ХБИ-ийн сонгох эрхийг хууль эрх зүйн актуудаар зохицуулж өгсөн байдаг ч бэрхшээлийн хэлбэрээр хэт ерөнхийлсөн, бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байдгаас болж ХБИ зохих ёсоор, бие дааж сонгох эрхээ эдлэхэд асуудал тулгардаг. Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд санал авах байрны хүртээмжгүй байдал илүү асуудал болдог бол харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа бие дааж, нууцаар, чөлөөтэй өгөх эрх нь илүү зөрчигддөг байна. Сонсголтгүй иргэдийн эх хэл нь дохионы хэл байдаг бөгөөд бичгийн хэлний чадвараасаа шалтгаалан нэр дэвшигчдийн болон намын мөрийн хөтөлбөрөөс мэдээлэл авах боломж нь хязгаарлагддаг тул хэнийг сонгохоо мэдэхгүй байх, ойр дотны хүмүүсийн нөлөөнд автаж саналаа өгөх гэх мэтээр бие дааж шийдвэр гаргах эрх нь зөрчигддөг. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 46.27-д сонгуулийн сурталчилгаа нь дохионы хэлмэрчтэй байж болно гэж хуульчилсан нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх алхам болсон мэт боловч "...байж болно" гэсэн нь хоёрдмол санааг илэрхийлсэн зохицуулалт болжээ (УИХ-ын сонгуулийн тухай, 2019). Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хялбаршуулсан байдлаар бэлтгэж хүргэдэггүй, мөн бэрхшээлийн хэлбэрээр нь ялгаварлан гадуурхаж, хуулиар сонгох эрхийг нь хязгаарласан заалт байдаг нь ХЭТТ-ын 21 дүгээр зүйл (ХЭТТ, 1948), ИБУТЭТОУП-ын 25 дугаар зүйлд заасан тэгш сонгох эрхийг хамгаалах олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилддөг (ИБУТЭТОУП, 1976). Монгол Улсад эрх зүйн чадамжгүйг нь шүүхээр тогтоосон 6,000 гаруй оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байдаг гэсэн мэдээлэл байгаа ч албаны эх сурвалж тодорхой бус, мөн энэ төрлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох мэдээлэл хангалтгүй байна. Иймд оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн улс төр, нийгмийн оролцооны эрхийн хэрэгжилтийг илүү гүнзгийрүүлж судлах шаардлагатай.

Сонгогдох эрхийн тухайд төлөөллийн оролцоог дэмжих хууль эрх зүйн орчин хангалтгүй, дэд бүтэц, улс төрийн намууд бодлогоор төлөөллийн оролцоог дэмждэггүй, хөгжлийн бэрхшээлийн талаар хандлага ойлголт сул байдгаас шалтгаалж ХБИ улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд гарах боломж тун хомс байна. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоог

хуулиар баталгаажуулсан боловч нийгмийн бүлгүүдийн тэр дундаа ХБИ-ийн төлөөллийг хангах талаар огт тусгаагүй. 2023 оны 7 сарын 7-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хуулийн 8.5. Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана (Улс Төрийн Намын Тухай Хууль, 2023) гэж заасан ч төлөөллийг яаж оролцуулах зохицуулалтаа албан ёсоор дүрэмдээ тусгасан нам одоогоор эрх барьж буй 3 намын дунд байхгүй.

Судалгааны үр дүнд тулгуурлан үзэхэд ХБИ-ийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал хангалтгүй байгааг тэмдэглэж байна.

ЗӨВЛӨМЖ

ХБИ-ийг улс төрийн үйл ажиллагаанд оролцох боломж, хүртээмжийг сайжруулах зорилгоор доорх зөвлөмжийг судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулав.

Хууль, эрх зүйн хүрээнд:

- Шийдвэр гаргах түвшин дэх төлөөллийн оролцоог дэмжих заалтыг холбогдох хуульд тусгах, хэрэгжилтийг хангах,
- Сонгох, сонгогдох эрхээ эдлэх явцад гарсан хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэх, буруутай талд хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг тодорхой болгох,
- Улс төрийн намууд ХБИ-ийн улс төрийн оролцоог бодлогоор дэмжих, дүрэмдээ албан ёсоор зохицуулалт оруулах,

Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдийн хувьд:

- Сонгуулийн хэсгийн хороодыг аль болох тэргэнцэртэй иргэд нэвтрэх боломжтой, хүртээмжтэй барилга, объектыг сонгож байршуулах,
- ХБИ-ий шаардлагыг тооцсон орон зай, орчинг сонгуулийн санал авах байруудад мөрдөж ажиллах (Монгол Улсын стандарт, 2009),

Харааны бэрхшээлтэй иргэдийн хувьд:

- Харааны бэрхшээлтэй иргэдийн харааны чадвар алдалтаасаа шалтгаалаад хэрэглэгдэхүүн нь өөр өөр байдаг тул санал авах байр бүрд брайль хавтаснаас гадна томруулдаг шил, нэмэлт гэрэлтүүлэгч тавих,
- Технологийн дэвшлийг санал авахад ашиглах боломжийг эрэлхийлэх. Ингэснээр ХБИ бэрхшээлийн хэлбэрээс үл шалтгаалан саналаа бие дааж, нууцаар өгөх боломжоор хангагдахаас гадна, орон зайн асуудал, цаг хугацааг хэмнэх, санал хаягдах эрсдлийг тодорхой хэмжээнд шийдвэрлэх олон талын ач холбогдолтой,
- Брайль тэмдэглэгээтэй хавтасны дугуйлдаг хэсгийн хүрээг саналын нууцлалыг хангах зорилгоор бэхтэй ижил өнгөтэй хэвлэх,
- Саналын хуудасны нүүр болон ар тал ялгагдаж болохоор хэвлэх,

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн хувьд:

- Сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахын тулд дохионы хэлмэртэй байх, дүрстэй мэдээлэлд текстэн тайлбар оруулах,

Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн хувьд:

- Бичиг үсгийн чадвар муутай болон оюуны бэрхшээлтэй сонгогчдын мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор сонгуультай холбоотой аливаа мэдээллийг (үүнд:

сонгогчийн боловсрол зориулсан болон улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр гэх мэт бичиг баримтууд орно) ойлгоход хялбаршуулсан энгийн үг хэллэг, зурган байдлаар бэлтгэн түгээх,

- Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хязгаарласан заалтыг Олон Улсын Байгууллагуудын өгсөн зөвлөмжийн дагуу эргэн харах, бэрхшээлийн хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх.

Явуулын хайрцагаар санал авахад:

- Явуулын хайрцагаар санал авах явцад сонгогчийн саналын нууцлалыг маш сайн хангах, хяналтыг сайжруулах.

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа:

- Хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага ойлголтыг сайжруулах зорилгоор улс төрийн намууд, Сонгуулийн ерөнхий хороо сургалт, нөлөөллийн ажлыг ХБИ-ийн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд өгөгдөл дээр ажиллах боломжоор хангасан Хүний Эрх Дэвшилтэт Бодлогын Хүрээлэнгийн Захирал Х.Баасанжаргал болон хүрээлэнгийн хамт олонд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

НОМЗҮЙ

https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_3900_004V1&Disability_select_all=0&DisabilitySingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2022&viewtype=table

Сүхбаатар.Ш, Дэлгэрнарэн.И. (2022). Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК

ХЭТТ. (1948, 12 10). Retrieved from www.legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/1271>

ИБУТЭТОУП. (1976, 03 23). Retrieved from www.legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail/1257>

Улс Төрийн Намын Тухай Хууль. (2023, 07 07). Retrieved from www.legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>

ХБХХЕГ. (2023). Retrieved from <http://www.gadpwd.gov.mn/>: <http://www.gadpwd.gov.mn/index.php/page/591>

ХБХ эрхийн тухай конвенц. (2008, 12 19). Retrieved from www.legalinfo.mn:

Инчоны Стратеги. (2012, 11). Retrieved from www.unescap.org:

<https://www.unescap.org/sites/default/d8files/incheon%20strategy%20%28mongolian%29.pdf>

ХБХ эрхийн тухай. (2016, 02 05). Retrieved from www.legalinfo.mn:

УИХ-ын сонгуулийн тухай. (2023, 06 16). Retrieved from www.legalinfo.mn:

Улс төрийн намын тухай. (2023, 07 07). Retrieved from www.legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>

Намын үндсэн дүрэм. (2022). Retrieved from www.nam.mn:

<http://www.nam.mn/%D0%BD%D0%B0%D0%BC%D1%8B%D0%BD-%D0%B4%D2%AF%D1%80%D1%8D%D0%BC>

Ардчилсан Намын дүрэм. (2024). Retrieved from [www.democraticparty.mn](http://democraticparty.mn): <http://democraticparty.mn/page/27>

ХҮН Намын дүрэм. (2022, 04 30). Retrieved from www.hunnam.mn: <https://www.hunnam.mn/en/rule>

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай. (2020, 12 24). Retrieved from www.legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891958781>

УИХ-ын сонгуулийн тухай. (2019, 12 20). Retrieved from www.legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail/14869>

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай. (2020, 01 30). Retrieved from www.legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail/15125>

АИХЭГ. (2013-2021). Retrieved from www.osce.org: <https://www.osce.org/odihr/elections/mongolia/>

ХБИ-ийн сонгох эрхийн хэрэгжилт. (2021, 01 31). Retrieved from www.uih.mn:

https://www.uih.mn/upload/sudalгаа/files/156_3769353.pdf